



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 5/16

Модот

┌ **А.Гансүхийг ажилд томилох тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Адилбишийн Гансүхийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажилд томилсугай.


2.А.Гансүхийн сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэлээр 1,399,000 (Нэг сая гурван зуун ерэн есөн мянган) төгрөгөөр бодож бусад нэмэгдлийг зохих журмын дагуу олгохыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3.Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд
Ажлын хэсгийн дарга Д.Өсөхгэрэл - Мал үржүүлэг, технологийн ажил
үйлчилгээний хяналтын Улсын байцаагч

Нарийн бичгийн дарга	Е.Нармандах	-	Архив, бичиг хэргийн эрхлэгч
Гишүүд	М.Ганчимэг	-	Нийгмийн даатгалын байцаагч
	Б.Буяндэлгэр	-	Санхүү албаны нягтлан бодогч
	С.Ган-Очир	-	Засаг даргын Тамгын газрын нярав

4.Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан сахиж, идэвхи санаачлагатай, хариуцлагатай хууль журмын дагуу ажиллахыг (А.Гансүх) -д үүрэг болгосугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО